

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Цогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/168/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Төгс нотолгоо аудит ХХК-ийн Ахлах аудитор: Г.Цэцэгмаа

Утас: 99889665

Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhand@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 02. 16

№

65

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу дагуу Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант онд эхний хагас жил болон эд хариуцагч солигдоход эд хөрөнгийн тооллого хийгээгүй,
- Эд хариуцагч нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын падаан, нэхэмжлэх, орлогын баримтгүй, анхан шатны баримтаар баталгаажаагүй тайлан гаргасан,
- Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны бүтээгдэхүүний орц нормд тавих өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлээгүйгээс батлагдсан нормативтаас 6,083.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан,

ЦОГТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХБОЛД
ТАНАА

822505000186

- Тайлант онд 20,289.9 мянган төгрөгийн өглөг үүсгэж, төсвийг зохистой удирдаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт 144,284.4 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн нэмэгдэлтэй холбоотой байна. Тайлант онд гүйцэтгэлээр 2,096,618.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 6.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд эд хариуцагч нь хүнсний материалын тайлан гарахдаа бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын падаан, нэхэмжлэх, орлогын баримтгүй, анхан шатны баримтаар баталгаажуулж тайлан гаргасан байна.

Бусад асуудал

Тайлант онд 6 хөтөлбөр, 50 зорилт, 16 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 29 арга хэмжээг бүрэн, 45 арга хэмжээг дутуу, нийт дүнгээр 88.2 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Боловсролын газраас үнэлээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>367,365,139.66</u>	<u>364,236,943.21</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	193,904,032.76	228,869,751.41
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	193,904,032.76	228,869,751.41
3121	Төгрөг	193,904,032.76	228,869,751.41
31211	Төрийн сангийн харилцах	193,904,032.76	228,869,751.41
33	АВЛАГА	3,761,900.00	-
335	Бусад авлага	3,761,900.00	-
33510	Байгууллагаас авах авлага	3,761,900.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	169,699,206.90	135,367,191.80
351	Түүхий эд материал	94,064,597.04	83,768,103.04
35110	Тусгай зориулалттай материал	93,069,397.04	83,144,403.04
35130	Эм боох материал	995,200.00	623,700.00
354	Хангамжийн материал	53,590,410.00	26,255,210.00
35410	Бичиг хэргийн материал	1,855,300.00	-
35420	Аж ахуйн материал	650,100.00	-
35440	Түлш, шатах тослох материал	5,200,000.00	3,780,000.00
35450	Барилгын засварын материал	11,680,000.00	4,236,000.00
35460	Хүнсний материал	34,205,010.00	18,239,210.00
35470	Бусад хангамжийн материал		
35500	Биологийн хөрөнгө	22,044,199.86	25,343,878.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>829,481,263.05</u>	<u>825,887,626.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	829,481,263.05	825,887,626.00
39100	Газар		
392	Биет хөрөнгө	804,150,763.05	800,557,126.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	891,680,866.59	891,680,866.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	(392,266,032.15)	(425,724,917.43)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,500,000.00	31,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,802,334.52)	(24,952,334.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	371,270,426.70	362,323,159.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(165,431,433.77)	(149,502,019.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	163,880,948.70	124,661,509.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(119,958,658.64)	(46,470,853.93)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,000,000.00	3,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	82,272,160.28	82,272,160.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(39,995,180.14)	(48,230,443.65)
393	Биет бус хөрөнгө	25,330,500.00	25,330,500.00
39301	Програм хангамж	2,615,298.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,615,298.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	25,330,500.00	25,330,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,196,846,402.71</u>	<u>1,190,124,569.21</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>46,389,862.00</u>	<u>20,289,944.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	46,389,862.00	20,289,944.00

Говь-Алтай аймгийн Цогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

413	Өглөг		46,389,862.00	20,289,944.00
4136	Бусад өглөг		46,389,862.00	20,289,944.00
41361	Байгууллагад төлөх өглөг		45,970,454.00	20,289,944.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		419,408.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		<u>1,150,456,540.71</u>	<u>1,169,834,625.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо		1,150,456,540.71	1,169,834,625.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,181,487,146.10	1,181,487,146.10
51101	Өмч: - төрийн		1,181,487,146.10	1,181,487,146.10
512	Хуримтлагдсан үр дүн		(342,662,456.22)	(323,284,371.72)
51210	Өмнөх үеийн үр дүн		(353,919,630.33)	(342,662,456.22)
51220	Тайлант үеийн үр дүн		11,257,174.11	19,378,084.50
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс			
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		311,631,850.83	311,631,850.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		<u>1,196,846,402.71</u>	<u>1,190,124,569.21</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,251,361,825.27	2,519,589,020.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,278,125.10	96,719,520.21
120	Нийтлэг татварын бус орлого	48,278,125.10	96,719,520.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	5,479,241.31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,479,241.31
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	41,217,135.48	87,810,600.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,060,989.62	3,429,678.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,203,083,700.17	2,422,869,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,952,333,600.17	2,096,618,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,952,333,600.17	2,096,618,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,011,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,011,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	248,739,100.00	326,251,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	248,739,100.00	326,251,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,238,219,156.24	2,500,210,935.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,238,219,156.24	2,500,210,935.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,196,136,655.86	2,425,825,657.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,478,307,800.65	1,620,798,512.93
210101	Үндсэн цалин	932,734,190.72	990,815,243.52
210102	Нэмэгдэл	469,345,738.23	526,325,453.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	48,494,300.00
210104	Урамшуулал	76,227,871.70	55,163,516.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,724,605.86	194,791,760.24
210201	Тэтгэврийн даатгал	123,706,832.00	129,366,379.40
210202	Тэтгэмжийн даатгал	14,473,277.00	16,595,642.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,337,968.00	8,292,717.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,087,006.00	8,108,270.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,119,522.86	32,428,751.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	249,355,225.62	301,424,339.88

**Говь-Алтай аймгийн Цогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210301	Гэрэл, цахилгаан	9,623,206.62	8,467,414.08
210302	Түлш, халаалт	233,832,019.00	284,782,892.99
210303	Цэвэр, бохир ус	5,900,000.00	8,174,032.81
2104	Хангамж, бараа материалын зардал	39,747,423.71	37,090,044.00
210401	Бичиг хэрэг	7,402,500.00	9,621,800.00
210402	Тээвэр, шатахуун	14,224,020.00	5,964,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,935,050.00	9,789,100.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	6,185,853.71	11,714,994.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨУГ/		
2105	Нормативт зардал	87,380,560.00	127,760,180.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	594,380.00
210502	Хоол, хүнс	87,380,560.00	127,165,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,467,600.00	8,128,000.00
210604	Урсгал засвар	16,467,600.00	8,128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,772,029.85	21,490,599.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,880,550.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,772,029.85	19,610,049.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,381,410.17	114,342,221.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,792,950.00	9,476,084.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,761,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,588,460.17	101,104,237.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,082,500.38	74,385,278.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,082,500.00	62,242,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,082,500.00	62,242,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.38	12,142,778.12
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага		
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.38	12,142,778.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,142,669.03	19,378,084.50
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,885,494.92	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,885,494.92	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,885,494.92)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	11,257,174.11	19,378,084.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,203,083,700.17	2,428,348,741.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,479,241.31
120	Нийтлэг татварын бус орлого	-	5,479,241.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	5,479,241.31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,479,241.31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,203,083,700.17	2,422,869,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,952,333,600.17	2,096,618,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,952,333,600.17	2,096,618,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,011,000.00	-

Говь-Алтай аймгийн Цогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,011,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	248,739,100.00	326,251,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	248,739,100.00	326,251,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,102,762,915.36	2,383,683,022.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,102,762,915.36	2,383,683,022.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,071,361,339.98	2,319,825,244.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,476,929,564.65	1,622,176,748.93
210101	Үндсэн цалин	931,355,954.72	992,193,479.52
210102	Нэмэгдэл	469,345,738.23	526,325,453.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	48,494,300.00
210104	Урамшуулал	76,227,871.70	55,163,516.00
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	181,724,605.86	194,791,760.24
210201	Тэтгэврийн даатгал	123,706,832.00	129,366,379.40
210202	Тэтгэмжийн даатгал	14,473,277.00	16,595,642.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,337,968.00	8,292,717.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,087,006.00	8,108,270.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,119,522.86	32,428,751.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	226,841,599.62	314,108,721.88
210301	Гэрэл, цахилгаан	9,623,206.62	8,467,414.08
210302	Түлш, халаалт	211,318,393.00	297,467,274.99
210303	Цэвэр, бохир ус	5,900,000.00	8,174,032.81
2105	Нормативт зардал	112,342,920.00	120,632,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	112,342,920.00	120,632,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,547,500.00	-
210604	Урсгал засвар	21,547,500.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,772,029.85	21,490,599.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,880,550.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,772,029.85	19,610,049.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,203,120.00	46,624,914.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,835,720.00	39,624,914.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,367,400.00	7,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,401,575.38	63,857,778.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,401,575.00	51,715,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,401,575.00	51,715,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.38	12,142,778.12
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.38	12,142,778.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	100,320,784.81	44,665,718.65
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	38,475,900.00	9,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,475,900.00	9,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	38,475,900.00	9,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	38,475,900.00	9,700,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(38,475,900.00)	(9,700,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	61,844,884.81	34,965,718.65
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	132,059,147.95	193,904,032.76

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	193,904,032.76	228,869,751.41
----	---	----------------	----------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	-353,043,643.35	1,140,075,353.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-875,986.98	-875,986.98
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	-353,919,630.33	1,139,199,366.60
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	11,257,174.11	11,257,174.11
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	-342,662,456.22	1,150,456,540.71
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	-342,662,456.22	1,150,456,540.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	-342,662,456.22	1,150,456,540.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	19,378,084.50	19,378,084.50
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,181,487,146.10	311,631,850.83	-323,284,371.72	1,169,834,625.21

2.5 Аудт хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант он			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,615,865,000.0	2,372,939,244.5	237,925,755.46	91%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,615,865,000.0	2,372,939,244.5	237,925,755.5	91%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,563,842,200.0	2,326,224,244.54	237,617,955.5	91%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,811,426,500.0	1,622,176,748.93	189,249,751.1	90%
210101	Үндсэн цалин	1,168,241,100.0	992,193,479.52	176,047,620.5	85%
210102	Нэмэгдэл	606,810,700.0	526,325,453.41	80,485,246.6	87%
210103	Унаа хоолны хөнгөлөлт		48,494,300.00	(48,494,300.0)	0%
210104	Урамшуулал	36,374,700.0	55,163,516.00	(18,788,816.0)	152%

**Говь-Алтай аймгийн Цогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	226,428,100.0	194,791,760.24	31,636,339.8	86%
210201	Тэтгэврийн даатгал	153,971,200.0	129,366,379.40	24,604,820.6	84%
210202	Тэтгэмжийн даатгал	18,114,200.0	16,595,642.84	1,518,557.2	92%
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,057,100.0	8,292,717.00	764,383.0	92%
210204	Ажилгүйдлийн даатгал	9,057,100.0	8,108,270.00	948,830.0	90%
210205	Эрүүл мэндийн даатгал	36,228,500.0	32,428,751.00	3,799,749.0	90%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	321,251,500.0	314,108,721.88	7,142,778.1	98%
210301	Гэрэл, цахилгаан	11,000,000.0	8,467,414.08	2,532,585.9	77%
210302	Түлш, халаалт	304,251,500.0	297,467,274.99	6,784,225.0	98%
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.0	8,174,032.81	(2,174,032.8)	136%
210502	Хоол, хүнс	125,632,500.0	120,632,500.00	5,000,000.0	96%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.0	6,399,000.00	(1,399,000.0)	28%
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,399,000.00	(1,399,000.0)	0%
210604	Урсгал засвар	5,000,000.0	5,000,000.00	-	0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	21,490,599.04	(21,490,599.0)	0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,880,550.00	(1,880,550.0)	0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	19,610,049.04	(19,610,049.0)	0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,103,600.0	46,624,914.45	27,478,685.6	63%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,211,200.0	39,624,914.45	25,586,285.6	61%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,892,400.0	7,000,000.00	1,892,400.0	79%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,022,800.00	63,857,778.12	307,800.00	99%
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,022,800.0	51,715,000.00	307,800.0	99%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,022,800.0	51,715,000.00	307,800.0	99%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	12,142,778.12	-	0%
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,142,778.12	-	0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,819,557,300.0	2,422,869,500.00	408,830,578.1	86%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,317,843,600.0	2,096,618,000.00	221,225,600.0	90%
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,317,843,600.0	2,096,618,000.00	221,225,600.0	90%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	326,251,500.0	326,251,500.00	12,142,778.1	96%
132001	Орон нутгийн төсвөөс	326,251,500.0	326,251,500.00	12,142,778.1	96%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,880,600.0	-	1,880,600.0	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,400.0	-	460,400.0	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	173,121,200.0	-	173,121,200.0	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		193,904,032.76		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		228,869,751.41		

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитын залруулга

Аудитаар 82,026.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналлын 5 алдаа¹-г аудитын явцад залруулж, тайлагнаж ирснийг баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны 5,479.2 мянган төгрөгийн орлогыг дансны ангилал буруу тайлагнасан
- Тайлант онд акталсан 11,714.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 1,850.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын мөнгөн зардлаар тайлагнаагүй

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд зарцуулсан зардлын 62,242.5 мянган төгрөгийг хоол, хүнсний зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн
- Бараа материалын шинжтэй 3 нэр төрлийн 740.0 мянган төгрөгийн материалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

Залруулагдаагүй нийт 182,811.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 182,811.9 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 560.7 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 172,347.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 9,903.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлээ.

3.2 Төлбөрийн акт

Эд хариуцагч нь хүнсний материалын тайлангийн зарлага менюны түүврээс 560.7 мянган төгрөгөөр илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага

Эд хариуцагч нь хүнсний материалын тайлан гарахдаа бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын падаан нэхэмжлэх, орлогын баримтгүй, анхан шатны баримтаар баталгаажаагүй тайлан гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; 20.2.3-т заасан "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 3,820.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж, төсвийг зохистой удирдаагүй нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант онд өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлж ажиллах.

Хоёр. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны эхний хагас жил болон эд хариуцагч солигдоход эд хөрөнгийн тооллого хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогын хуульд заасан хугацаанд үр дүнтэй хийж хэвших.

Гурав. Баталсан бүтэц орон тоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн тушаалаар өдөрт 5.0 мянган төгрөгөөр тоохон цалингийн зардлаас 48,494.3 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах"-тай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид унаа хоолны хөнгөлөлтийг төсвийн төсөлд тусган, баталсан зардлын хүрээнд зарцуулах.

Дөрөв. Хоолны нормативт зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сургуулийн дотуур байрны хоолны бүтээгдэхүүний орц нормд тавих өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлээгүйгээс батлагдсан нормативтаас 6,083.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны 254 дүгээр тогтоол Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300 (зургаан мянга гурван зуу) төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000 (зургаан мянга) " гэж заасныг зөрчсөн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид дотуур байрны хоолны зардлыг нормативт зардлын хүрээнд зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймгийн сумын Говь-Алтай аймгийн Цогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Дөрөв . АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Цогт сумын ерөнхий боловсролын сургууль	Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны 5,479.2 мянган төгрөгийн орлогыг дансны ангилал буруу тайлагнасан	1	5,479.2			1	5,479.2	1	5,479.2				
	Тайлант онд акталсан 11,714.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар тайлагнасан	1	11,714.9			1	11,714.9	1	11,714.9				
	Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 1,850.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын мөнгөн зардлаар тайлагнаагүй	1	1,850.0			1	1,850.0	1	1,850.0				
	Төрөөс иргэдэд олгох Тэтгэмж, урамшуулалд зарцуулсан зардлын 62,242.5 мянган төгрөгийг хоол, хүнсний зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	62,242.5			1	62,242.5	1	62,242.5				
	Бараа материалын шинжтэй 3 нэр тэрлийн 740.0 мянган төгрөгийн материалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн	1	740.			1	740.	1	740.				
ДҮН		5	82,026.6			5	82,026.6	5	82,026.6	-	-	-	-

4.2. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1		3	4	5	6	7	8	9	10	11	12
	Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025	1	-					1			

Говь-Алтай аймгийн сумын Говь-Алтай аймгийн Цогт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Говь-Алтай аймгийн Цогт сумын ерөнхий боловсролын сургууль	оны "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийг үндэслэн тушаалаар едөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 48494.3 мянган төгрөгийг олгосон байна.										
	Эд хариуцагч нь хүнсний материалын тайлангийн зарлага менюны түүврээс 560.7 мянган төгрөгөөр илүү зарцуулсан	1	560.7	1	560.7					-	
	Тайлант онд 3,820.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж төсвийг зохистой удирдаагүй байна.	1	3,820.7					1	3,820.7		-
	Тайлант онд эхний хагас жил болон эд хариуцагч солигдоход эд хөрөнгийн тооллого хийгээгүй байна.	1	0					1	0		-
	Сургуулийн дотуур байрны хоолны бүтээгдэхүүний орц нормд тавих өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлээгүйгээс батлагдсан нормативтаас 6,083.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.	1	6,083.0					1	6,083.0		
Эд хариуцагч нь хүнсний материалын тайлан гарахдаа бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын падаан нэхэмжлэх, орлогын баримт байхгүй, анхан шатны баримтаар баталгаажуагүй тайлан гаргасан байна	1	172,347.5				1	172,347.5				
Дүн	6	182,811.9	1	560.7	1	172,347.5	4	9,903.7		-	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй						
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		